



**ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/02


Баян-Өндөр сум

“Монголын Үндэсний спортын VIII наадмын”
өвлийн төрлийн шигшээ тэмцээнд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 4.3 дахь заалт, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/367 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Үндэсний спортын VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтын дагуу санхүүжилтийн гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), үндэсний болон өвлийн спортын асуудал, сургалт, дасгалжуулалт хариуцсан мэргэжилтэн (О.Заяа) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тэмцээнд зарцуулагдах 5,130,000 (таван сая нэг зуун гучин мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Э.Баасанням)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д. ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн
10/02 дугаар тушаалын хавсралт

VIII НААДМЫН ӨВЛИЙН ТӨРЛИЙН ШИГШЭЭ
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

1. Мөсний сурын харваа төсөв:

№	Зардлын нэр	Өдөр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд (төгрөгөөр)
1.	Хоолны зардал	4	12	30,000	1,440,000
2.	Байрны зардал	3	12	30,000	1,080,000
3.	Унааны зардал ЭТ-УБ-ЭТ	2 тал	12	30,000	720,000
Дүн					3,240,000

2. Мөсний шагайн харваа төсөв:

№	Зардлын нэр	Өдөр	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд (төгрөгөөр)
1.	Хоолны зардал	4	7	30,000	840,000
2.	Байрны зардал	3	7	30,000	630,000
3.	Унааны зардал ЭТ-УБ-ЭТ	2 тал	7	30,000	420,000
Дүн					1,890,000
Төсвийн нийт дүн					5,130,000